Төсөл

МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү дүрмийн зорилго нь Мэдээлэл холбооны мэргэжлийн нэгдсэн холбоо (цаашид “МНХ” гэх) -ны зорилго, үнэт зүйл, зарчим, үйл ажиллагааны чиглэл, бүтэц, зохион байгуулалт, удирдлага, шийдвэр гаргалт, хяналт, санхүүжилт, гишүүнчлэлийн тогтолцоо, МНХ-г өөрчлөх болон татан буулгах үндэслэл зэргийг тогтооход оршино.

1.2 МНХ нь Монгол Улсын нутаг дэвсгэрт мэдээлэл холбооны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн холбоодын гишүүнчлэлтэй, мэдээлэл холбооны салбарын болон мэргэжлийн нийтлэг эрх ашгийг хамгаалах салбарын бизнес эрхлэгчдийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн бизнесийн таатай орчныг бүрдүүлэхийн төлөө салбартаа болон гишүүддээ үйлчилдэг, үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрөө өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг, ашгийн бус, МНХ байна.

1.3 МНХ нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай, Төрийн бус байгууллагын тухай болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

1.4 Үүсгэн байгуулагчид МНХ-оог байгуулах шийдвэр гаргаж, дүрмээ баталж, улсын бүртгэлд бүртгүүлснээр тус хуулийн этгээдийг байгуулагдсанд тооцно.

1.5 МНХ-ны оноосон нэр: **“Мэдээлэл холбооны мэргэжлийн нэгдсэн холбоо”**
Англи нэр: “Mongolian Information and Communication Alliance”

1.6 МНХ нь бие даасан хуулийн этгээд байх бөгөөд өөрийн бэлгэдэл, тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудастай байна.

1.7 МНХ нь өөрийн эрхэм зорилго, зарчимтай байна. МНХ-ны бүх бодлого, стратеги, шийдвэр, үйл ажиллагаа нь дүрэмд тусгагдсан эрхэм зорилго, зарчимд суурилна.

Хоёр. Мэргэжлийн нэгдсэн холбооны хаяг, байршил

2.1 Хаяг: Сити Плаза #302, Сөүлийн гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот

2.2 Харилцах утас: 76079900

2.3 Цахим шуудан: info@micoa.mn

2.4 Веб хуудас:www.micoa.mn

Гурав. Үүсгэн байгуулагчид

3.1 Мэдээлэл холбооны операторуудын ассоциаци
Регистрийн дугаар: 8265801
Улсын бүртгэлийн дугаар: 9072013006

3.2 Мэдээлэл холбооны үндэсний ассоциаци
Регистрийн дугаар: 1009362
Улсын бүртгэлийн дугаар: 9072004012

3.3 Монголын олон суваг дамжуулагчдын холбоо
Регистрийн дугаар: 8320934
Улсын бүртгэлийн дугаар: 9072014079

3.4 Мэдээлэл холбооны дэд бүтцийн угсралт, суурилалтын ажил эрхлэгчдийн холбоо

Регистрийн дугаар: 8019827
Улсын бүртгэлийн дугаар: 9072003063

3.5 Монголын оюуны өмч хамгаалах холбоо
Регистрийн дугаар:8232512
Улсын бүртгэлийн дугаар: 9072011144

Дөрөв. Зорилго

4.1 Монгол Улсын мэдээлэл холбооны салбарын үр ашигтай, эрүүл, тогтвортой өсөлт, хөгжлийг дэмжих бизнесийн орчныг бий болгох чиглэлээр салбарын зохицуулалтын болон төр засгийн байгууллагуудад бодлогын нөлөөлөл үзүүлэх салбарын тэргүүлэх мэргэжлийн байгууллага байж, гишүүн мэргэжлийн холбоодыг нэгдсэн удирдлагаар хангана.

Тав. Баримтлах зарчим, үнэт зүйлс

5.1 Салбарын болон мэргэжлийн эрх ашгийг нэн тэргүүнд эрхэмлэнэ.

5.2 Засаглал, үйл ажиллагаа нь ил тод, шударга өрсөлдөөний зарчмыг дээдэлсэн, хууль тогтоомжийн хүрээнд байна.

5.3 Асуудалд мэргэжлийн байр сууринаас хандаж, бизнесийн ёс зүйг эрхэмлэнэ.

5.4 Улс төрийн нам, хөдөлгөөний үйл ажиллагаанаас ангид байна.

Зургаа. Үйл ажиллагааны үндсэн чиглэл

6.1 Салбарын болон гишүүн мэргэжлийн холбоодын нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, төлөөлөн илэрхийлэх, төрийн аль ч шатны байгууллагад өөрийн байр суурыа илэрхийлэх;

6.2 Салбарын хууль эрх зүй, бодлого, зохицуулалтын асуудлаар дүгнэлт, санал, зөвлөмж, мэдэгдэл гаргах, шаардлага тавих, төрийн байгууллага, бодлого, зохицуулалтын болон бусад байгууллагуудтай харилцан ойлголцох, итгэлцэл, түншлэлийг бий болгох чиглэлээр хамтран ажиллах;

6.3 Салбарын хууль тогтоомж, бодлого, зохицуулалтын баримт бичиг, хэм хэмжээний актууд, стандарт, норм, шийдвэрийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий зөвлөл, хороо, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах, санал, зөвлөмж гаргах;

6.4 Харилцаа холбооны үйлчилгээний зөвшөөрөл шинээр бий болгох, зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг өөрчилж дүгнэлт гаргахад санал өгөх, шаардлагатай тохиолдолд тухайн зөвшөөрлийн хэрэгцээ шаардлага, эрсдэлийн түвшин, үнэлгээний талаар санал, дүгнэлт гаргах;

6.5 Салбарт өндөр технологи, инновац, үйлдвэрлэл нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн үйл ажиллагааны стандарт, нормативын баримт бичиг боловсруулах, мөрдүүлэх, хэрэглээний тайлбар, зөвлөмж бэлтгэх;

6.6 Салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ, технологийн түвшнийг тогтоох, үнэлэх, борлуулалт, бараа, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварт мэргэжлийн үнэлгээ, дүгнэлт өгөх;

6.7 Төрийн болон зохицуулах байгууллагын зарим чиг үүргийг хууль, гэрээний үндсэн дээр гүйцэтгэх;

6.8 Салбарын хүний нөөцийн бодлогыг тодорхойлох, мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах, мэргэшил дээшлүүлэх сургалт зохион байгуулах, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулахад оролцох, санал, дүгнэлт, зөвлөмж гаргах;

6.9 Гишүүд хоорондын мэдээллийн солилцоог идэвхжүүлэх замаар мэдлэг туршлагаа хуваалцах, хамтдаа хөгжих, тулгамдаж буй асуудлаа тодорхойлох, шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх;

6.10 МНХ-ны үйл ажиллагаа, үр нөлөө, санхүүг бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах, дэмжигч байгууллага, иргэдээс дүрмээр тодорхойлсон үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг авах;

6.11 Үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд гадаадын болон олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх.

Долоо. МНХ-ны бүтэц, зохион байгуулалт

7.1 МНХ нь Бүх гишүүдийн хурал, Ерөнхийлөгч, Удирдах зөвлөл, Ажлын алба, Мэргэжлийн зөвлөл, Хяналтын зөвлөл, гишүүн мэргэжлийн холбоод гэсэн бүтэцтэй байна.

7.2 МНХ-ны эрх барих дээд байгууллага нь Бүх гишүүдийн хурал байна.

7.3 Бүх гишүүдийн хурлын чөлөө цагт МНХ-ны бүрэн эрхийг Ерөнхийлөгчөөр ахлуулсан Удирдах зөвлөл энэ дүрэмд заасны дагуу хэрэгжүүлнэ.

Найм. Бүх гишүүдийн хурал[1]

8.1 Бүх гишүүдийн хурал нь МНХ-оог үүсгэн байгуулж буй мэргэжлийн холбоодын төлөөлөгчдөөс бүрдэнэ.

8.2 Бүх гишүүдийн хурал нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

8.2.1 МНХ-ны дүрмийг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах;

8.2.2 Ерөнхийлөгчийг сонгох, чөлөөлөх;

8.2.3 Удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх;

8.2.4 Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгох, чөлөөлөх;

8.2.5 Удирдах зөвлөлийн шийдвэрээр Бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;

8.3 Хурал зохион байгуулах комисс хурлын товыг хурал болохоос өмнө дор хаяж хуанлийн гуч (30) хоногийн өмнө гаргаж, урилгыг бүх гишүүдэд хүргүүлнэ.

8.4 Бүх гишүүдийн хурлын төлөөлөгчдийн тоо нь тухайн гишүүнийг төлөөлөх Удирдах зөвлөлийн гишүүний тоог 3-р үржүүлсэнтэй тэнцүү байна.

8.5 Бүх гишүүдийн хуралд нийт төлөөлөгчдийн гуравны хоёроос(2/3) дээш хувь нь оролцсон тохиолдолд тус хурлыг хүчин төгөлдөр гэж үзнэ. Хуралд гишүүн бүр нэг саналын эрхтэйгээр оролцох бөгөөд бүх гишүүдийн хурлын шийдвэрийг нийт оролцогчдын ердийн олонхын саналаар гаргана.

8.6 Бүх гишүүдийн хурлыг удирдах, хурлын явц, зохион байгуулалттай холбогдсон асуудлыг шийдвэрлэх, хурлын шийдвэрийг албажуулах зэрэг чиг үүрэг бүхий хурал даргалагчийг тухайн хурлаас сонгоно. Хурлын явцыг хурлын тэмдэглэлд тусгана. Хурлын шийдвэрт хурал даргалагч гарын үсэг зурж баталгаажуулна.

Ес. Ерөнхийлөгч

[1] Бүх гишүүдийн анхдугаар хурлыг “Үүсгэн байгуулах хурал” гэж нэрлэнэ.

9.1 Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа гурван (3) жил байх бөгөөд улираан сонгогдохгүй байх зарчмыг баримтална[2].

9.2 Ерөнхийлөгчийн бүрэн эрх Бүх гишүүдийн хурлын шийдвэр гарсан өдрөөс эхэлж, Ерөнхийлөгчийг чөлөөлөх шийдвэр гарснаар дуусгавар болно.

9.3 Ерөнхийлөгч нь МНХ-ны үйл ажиллагааг удирдан холбогдох хууль тогтоомж, МНХ-ны зорилгод нийцсэн, энэхүү дүрэмд заасан эрх хэмжээний хүрээнд шийдвэр гаргана.

9.4 МНХ-ны Ерөнхийлөгч нь Удирдах зөвлөлийн дарга байна.

9.5 Энэ дүрмийн 9.8-д заасан шаардлагыг хангасан гэж үзсэн нэр дэвшигч нь МНХ-г үүсгэн байгуулах хурал болон цаашид Удирдах зөвлөлд өөрөө нэрээ дэвшүүлнэ.

9.6 Ерөнхийлөгч нь дараах эрхтэй:

9.6.1 МНХ-г гадаад, дотоод харилцаанд итгэмжлэлгүйгээр төлөөлөх;

9.6.2 Удирдах зөвлөлийн хурлыг даргалах, товлон зарлан хуралдуулах;

9.6.3 Дүрэмд заасан үйл ажиллагааг явуулахад чиглэсэн тодорхой асуудлын саналыг Удирдах зөвлөлийн хуралд хэлэлцүүлэхээр санал оруулах;

9.6.4 Холбогдох хууль болон энэхүү дүрэмд заагдсан холбооны үйл ажиллагааны чиглэлээр санал санаачилга гаргах, манлайлан чиглүүлэх;

9.6.5 Мэргэжлийн Нэгдсэн Холбооны Ажлын албаны дарга буюу (цаашид “Гүйцэтгэх захирал” гэх) Гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах, удирдамж чиглэл өгөх;

9.6.6 Удирдах зөвлөлийн хурлын тогтоолд гарын үсэг зурж баталгаажуулах;

9.6.7 Хууль болон энэхүү дүрэмд заасан бусад эрх;

9.7 Ерөнхийлөгч нь дараах үүрэгтэй:

9.7.1 Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, УИХ-ын байнгын хороо, төрийн болон зохицуулах байгууллагад МНХ-ны байр суурийг төлөөлөн илэрхийлэх;

9.7.2 МНХ-ны бодлого, стратегийн шийдвэр, салбар, гишүүн мэргэжлийн холбоодын эрх ашгийг хамгаалахтай холбоотой асуудлаар мэдээлэл хийх, байр сууриа илэрхийлэх, бодлогын нөлөөлөл үзүүлэх;

9.7.3 МНХ-ны стратеги төлөвлөгөөг боловсруулан Удирдах зөвлөлийн гишүүдээр батлуулах;

9.7.4 МНХ-ны гадаад харилцаа, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг идэвхжүүлэн, өргөжүүлэх;

9.7.5 Удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

9.7.6 Жил бүр үйл ажиллагааны тайлангаа Удирдах зөвлөлд тайлагнах.

9.8 Ерөнхийлөгчид нэр дэвшигчид тавигдах нийтлэг шаардлага:

9.8.1 Улсын их хурал, Засгийн газрын түвшинд салбарын хууль эрх зүйн орчин бүрдүүлэх, бодлого шийдвэр гаргахад төлөөлөх, нөлөөллийн үйл ажиллагааны туршлага, чадвартай, МНХ-ны үйл ажиллагаанд цаг хугацаа, сэтгэл гаргаж ажиллах боломжтой байх

[2] Улираан сонгохгүй гэдэгт дарааллан улиран сонгогдохгүй байх буюу тухайн Ерөнхийлөгч дахин нэр дэвших бол хамгийн багадаа өмнөх эрх үүрэг нь дуусгавар болсноос хойш 3 жилийн хугацаа өнгөрсөн байх, тус хугацааны дараа дахин нэр дэвших боломжтой байхыг ойлгоно.

9.8.2 Мэдээлэл, холбооны салбарын бодлого, зохицуулалтын чиглэлээр тодорхой мэдлэг, туршлага[3] бүхий, салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн эксперт байх;

9.8.3 Мэдээлэл, холбооны салбар, МНХ-оог бүрэн төлөөлөх мэдлэг ур чадвартай, илтгэх болон харилцааны ур чадвартай, хэвлэл мэдээллээр харилцах чадвартай байх;

9.8.4 Шударга ёсыг эрхэмлэдэг, ялгаварлан гадуурхахгүй байх, ёс зүйн өндөр хэм хэмжээг баримтлан ажилладаг байх;

9.8.5 Ерөнхийлөгчид нэр дэвшигчид тавигдах нарийвчилсан шаардлага, нэр дэвшигчийг бүртгэх, Бүх гишүүдийн хуралд танилцуулах, санал хураах зэргийг тусгасан журмыг Удирдах зөвлөл батална.

9.9 Ерөнхийлөгчийг чөлөөлөх, эргүүлэн татах:

9.9.1 Ерөнхийлөгч бөгөөд Удирдах зөвлөлийн дарга хүндэтгэн үзэх шалтгааны улмаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд Удирдах зөвлөлийн гишүүд дотроо санал хурааж, түр хуралдаан даргалагчийг томилно.

9.9.2 Ерөнхийлөгч өөрийн хүсэлтээр, хүндэтгэх шалтгаанаар чөлөөлөгдөх тохиолдолд Удирдах зөвлөлийн хурлаар үүрэг гүйцэтгэгчийг баталгаажуулж, нөхөн томилох ажлыг Удирдах зөвлөл зохион байгуулна.

9.9.3 Ерөнхийлөгч нь холбогдох хууль тогтоомж болон МНХ-ны зорилго, дүрэмд харшилсан үйл ажиллагаа явуулсан, явуулахаар завдсан, холбооны нэр хүндийг унагаж хүлээсэн үүргээ зөрчсөн, эрүүгийн ял шийтгэл хүлээсэн зэрэг тохиолдолд Удирдах зөвлөлийн хуралд танилцуулж, олонхын саналыг үндэслэн эргүүлэн татах асуудлыг Бүх гишүүдийн хурлаар шийдвэрлүүлнэ.

9.9.4 Удирдах зөвлөлийн гишүүдийн 2/3 нь (Гуравны хоёр) Ерөнхийлөгчийг ажил, үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн, чадамжгүй гэж дүгнэсэн тохиолдолд Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, шийдвэрлэнэ.

9.9.5 Нөхөн сонгогдсон Ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгчийн бүрэн эрх дараагийн ээлжит Их хурал хуралдах хүртэл үргэлжилнэ.

10. Удирдах зөвлөл

10.1. Удирдах зөвлөлийн нийт гишүүдийн тоо 17 байна.

10.2. Удирдах зөвлөлийн гишүүнийг дараах зарчмыг баримтлан гишүүн мэргэжлийн холбоодоос ирүүлсэн саналаар сонгоно.

10.2.1 Тухайн мэргэжлийн холбоог УЗ-д төлөөлөх гишүүдийн тоо нь тухайн мэргэжлийн холбооны салбарын нийт үйлдвэрлэл, борлуулалтад эзлэх хувь хэмжээтэй тэнцүү байна[4].

10.3. МНХ-г үүсгэн байгуулагчдаас Удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнийг энэ дүрмийн 10.2.1-т заасан зарчимд үндэслэн дараах байдлаар тогтооно.

10.3.1 Мэдээлэл холбооны операторуудын ассоциаци - 9 гишүүн;

10.3.2 Мэдээлэл холбооны үндэсний ассоциаци – 1 гишүүн;

[3] Бодлого, зохицуулалтын байгууллага, хувийн хэвшил, төрийн бус байгууллага болон бусад холбогдох байгууллагад ажилласан туршлагыг ойлгоно.

[4] Борлуулалт, нийт үйлдвэрлэлд эзлэх хувь жинг Эрх бүхий зохицуулагч байгууллагаас гаргасан статистик мэдээллийг үндэслэн тогтооно.

10.3.3 Олон суваг дамжуулагчдын холбоо – 3 гишүүн;
10.3.4 Харилцаа холбооны дэд бүтцийн угсралт, суурилалтын ажил үйлчилгээ эрхлэгчдийн холбоо – 1 гишүүн;
10.3.5 Монголын оюуны өмч хамгаалах холбоо – 3 гишүүн.

10.4. Цаашид МНХ-нд гишүүн шинээр элсүүлэхдээ энэ дүрмийн 10.2-г харгалзан Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг өөрчилж болно[5].

10.5. Удирдах зөвлөл дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
10.5.1 Бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулах, хурлын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх;
10.5.2 МНХ-ны бодлого, зорилго, стратегийг тодорхойлох, түүний хэрэгжилтэд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх;
10.5.3 Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах;
10.5.4 Гишүүнчлэлийн журмыг батлах, гишүүнчлэлийн татварын ангилал, шатлал, хэмжээг тогтоох, өөрчлөх;
10.5.5 Шинээр элсэх гишүүнийг хэлэлцэн батлах;
10.5.6 Удирдах зөвлөлийн хуралдааны дэгийг батлах;
10.5.9 Мэргэжлийн хороог томилох, ажиллах журмыг батлах
10.5.10 Ажлын албаны бүтэц, зохион байгуулалтыг батлах;
10.5.11 Ажлын албаны дарга буюу Гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх;
10.5.12 МНХ-ны өмч хөрөнгийг захиран зарцуулах талаар эрх хэмжээг тогтоох;
10.5.13 МНХ-ны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг хэлэлцэх, үнэлэлт өгөх, үйл ажиллагааны төлөвлөгөө, жилийн төсөв батлах;
10.5.15 Асуудалд шударга, бодитой хандах, МНХ-ны эв нэгдлийг хангах, нэгдмэл эрх, ашиг сонирхол, үнэт зүйлийг эрхэмлэх;
10.5.16 МНХ-ны хөрөнгө, санхүүгийн болон бусад чадавхыг бэхжүүлэх, тогтвортой байдлыг хадгалахад дэмжлэг үзүүлэх;
10.5.17 Ерөнхийлөгчөөс Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;
10.5.18 Хууль болон дүрэмд заасан бусад эрх, үүрэг.

Тайлбар: Нэгдмэл эрх, ашиг сонирхол гэдэг нь зөвхөн тухайн гишүүдэд нийтлэг тохиолдож болохуйц, эрх ашгийг нь хөндөхүйц бизнесийн орчны асуудлуудаар үүссэн ашиг сонирхлыг ойлгоно.

10.6. Удирдах зөвлөлийн гишүүнийг дараах үндэслэлээр чөлөөлнө. Үүнд:
10.6.1 Өөрөө хүсэлт гаргасан;
10.6.2 Нэр дэвшүүлсэн Мэргэжлийн холбооны саналаар;
10.6.3 Нэр дэвшүүлсэн Мэргэжлийн холбоо нь МНХ-ны гишүүнчлэлээс чөлөөлөгдсөн тохиолдолд;
10.6.5 Монгол Улсын Хууль тогтоомж, МНХ-ны дүрмийг удаа дараа ноцтой зөрчсөн тохиолдолд Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр;
10.6.6 Удирдах зөвлөлийн гишүүн хөдөлмөрчийн чадвараа алдсан, нас барсан тохиолдолд;

[5] Цаашид гишүүн нэмэхэд, УЗ-ын квотын тоонд өөрчлөлт оруулах эсэхийг Эрх бүхий зохицуулагч байгууллага буюу ХХЗХ-ноос гаргасан тухайн жилийн зах зээл, борлуулалтын хэмжээнд гарч буй өөрчлөлтөд үндэслэн шийдвэрлэнэ.

10.7. Удирдах зөвлөлийн гишүүн энэхүү дүрмийн 10.6-д заасны дагуу Удирдах зөвлөлөөс чөлөөлөгдсөн тохиолдолд түүний оронд түүнийг анх дэвшүүлсэн Мэргэжлийн холбооноос нөхөн нэр дэвшүүлж, Удирдах зөвлөлөөс тухайн гишүүнийг батламжилна.

Арван нэг. Удирдах зөвлөлийн хурал

11.1 Удирдах зөвлөлийн гишүүд хамтын шийдвэр гаргах ба бүрэн эрхээ хурлаар хэрэгжүүлнэ.

11.2 Удирдах зөвлөл ээлжит болон ээлжит бус хуралтай байна. Ээлжит хурал нь хагас жил тутам нэгээс доошгүй удаа хуралдана.

11.3 Удирдах зөвлөлийн даргыг түр эзгүйд даргын санал болгосон гишүүн хурлыг даргална.

11.4 Ээлжит бус хурлыг Ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн дарга, Хяналтын зөвлөл эсхүл Удирдах зөвлөлийн гишүүдийн гуравны нэг болон Гүйцэтгэх захирлын санаачилга шаардлагаар зарлан хуралдуулж болно.

11.5 Удирдах Зөвлөлийн хурлын тов болон хэлэлцэх асуудлыг Удирдах зөвлөлийн даргатай зөвшилцсөний үндсэн дээр Ажлын албанаас ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө зарлана.

11.6 Удирдах зөвлөлийн гишүүд хуралд биеэр оролцох бөгөөд хүндэтгэх шалтгааны улмаас оролцож чадахгүй тохиолдолд гишүүд өөрийн итгэмжилсэн төлөөлөгчийг хуралд илгээх эсвэл хурал болохоос өмнө хэлэлцэх асуудалд бичгээр, мэйлээр саналаа өгч болно.

11.7 Удирдах зөвлөлийн гишүүдийн 75% ба түүнээс дээш гишүүн нь Удирдах зөвлөлийн хуралд оролцсон тохиолдолд тухайн хурлыг хүчинтэй гэж үзнэ. Ижил асуудлаар хурлыг 1 удаа хойшлуулж болно.

11.8 Удирдах зөвлөлийн гишүүд аливаа асуудлыг шийдвэрлэхэд тэгш эрхтэй байх МНХ-ны дүрмийн өөрчлөлтийг Бүх Гишүүдийн хурлаар хэлэлцүүлэх эсэх асуудал, гишүүнчлэлтэй холбоотой асуудлыг 66,6%-иас дээш саналаар, бусад асуудлыг 51%-иас дээш саналаар батална. Асуудлыг илээр санал хураах зарчмаар шийдвэрлэнэ.

11.9 Удирдах зөвлөлийн хурлын шийдвэр тогтоол, хурлын тэмдэглэл хэлбэрээр гарна. Тогтоолд Удирдах зөвлөлийн дарга, хурлын тэмдэглэлд хуралд оролцсон бүх гишүүд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

11.10 Удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлд тухайн хурлаар хэлэлцсэн асуудал, баталсан тогтоол, санал хураалтын дүн, сонирхлын зөрчилтэй холбоотой тайлбар, гаргах тогтоолын талаар зарчмын өөр саналтай гишүүний тайлбар зэргийг тэмдэглэнэ. Гишүүн тайлбараа бичгээр гаргах эрхтэй.

Арван хоёр. Хяналтын зөвлөл

12.1 Хяналтын зөвлөл нь 5-аас доошгүй тооны гишүүнээс бүрдэх ба гишүүдийг Бүх гишүүдийн хурлаас 3 жилийн хугацаагаар томилно. Хяналтын зөвлөлд мэргэшсэн экспертүүдийн төлөөлөл 2-оос доошгүй байна.

12.2 Хяналтын зөвлөл нь МНХ-ны үйл ажиллагаа дүрэмд нийцэж буй эсэхэд болон хөрөнгийн хуримтлал, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих ба хяналт шалгалтын дүнг Удирдах зөвлөлд танилцуулна.

12.3 Хяналтын зөвлөл үйл ажиллагаандаа МНХ-ны нэгдмэл эрх, ашиг сонирхлыг бусад байгууллагын эрх, ашиг сонирхлоос дээгүүр тавих, үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх, асуудалд үнэн зөв, шударга, бодитой хандах, бие даасан, ил тод, нээлттэй байх зарчмыг удирдлага болгоно.

12.4 Хяналтын зөвлөл чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дараах эрх эдэлнэ. Үүнд:

12.4.1 МНХ-ны хөрөнгө, санхүүгийн үйл ажиллагаатай холбогдуулан гишүүдийн гаргасан гомдол, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдсан мэдээллийн дагуу шалгалт явуулах;

12.4.2 Хяналтын зөвлөлийн шийдвэр, хөндлөнгийн аудиторын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар гаргасан мэдээллийг хэлэлцэх;

12.4.3 Эд хөрөнгийн хуримтлал, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагаатай холбогдон гарсан зөрчлийн талаар дүгнэлт, зөвлөмж гаргах, шаардлагатай тохиолдолд холбогдох албан тушаалтанд шаардлага хүргүүлэх, биелэлтэд нь хяналт тавих;

12.4.4 Санхүүгийн үйл ажиллагаа, түүнд хамаарах эрх зүйн баримт бичгүүдийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах;

12.4.5 Шаардлагатай гэж үзвэл гишүүн холбоодын гомдол, мэдээлэлтэй холбоотой санхүүгийн бичиг баримтыг мэргэжлийн болон аудитын байгууллагаар хянуулж дүгнэлт гаргуулах;

12.4.6 МНХ-ны эд хөрөнгө, санхүүгийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцах;

12.4.7 Хууль, дүрэмд заасан бусад эрх.

Арван гурав. Ажлын алба

9.1 Ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагааг Гүйцэтгэх захирал шууд удирдан зохион байгуулж Удирдах зөвлөлд тайлагнана.

9.2 Удирдах зөвлөлийн хурлын болон цаг үеийн асуудлаар авах шаардлагатай арга хэмжээний талаарх Гүйцэтгэх захирлын шийдвэрийг хэрэгжүүлнэ.

9.3 Гүйцэтгэх захирал нь дараах эрхтэй:

13.3.1 Удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд МНХ-г итгэмжлэлгүйгээр төлөөлөх, өмч хөрөнгө, төсвийг захиран зарцуулах, гэрээ хэлцэл байгуулах;

13.3.2 Удирдах зөвлөлөөс олгосон эрх мэдлийн хүрээнд цаг үеийн асуудлаар шаардлагатай арга хэмжээ авах шийдвэр гаргах;

13.3.3 МНХ-ны нэрийн өмнөөс холбогдох байгууллагууд, олон нийттэй харилцах;

13.3.4 Ажлын албаны ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, тэднийг томилох, чөлөөлөх;

13.3.5 Хууль болон гэрээнд заасан бүрэн эрх.

9.4 Гүйцэтгэх захирал дараах үүрэгтэй:

13.4.1 МНХ-ны урт, богино хугацааны төлөвлөгөөг боловсруулан батлуулах, биелэлтийг хангах;

13.4.2 МНХ-ны дүрмийг болон их хурал, удирдах зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах;

13.4.3 МНХ-ны мэргэжлийн хороодын үйл ажиллагааг чиглүүлэх, удирдан зохион байгуулах;

13.4.4 Удирдах зөвлөлийн хурлын төлөвлөгөө, товыг Удирдах зөвлөлийн даргатай зөвшилцөж гаргах, Удирдах зөвлөлийн хурлыг зохион байгуулах;

13.4.5 МНХ-ны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, төсвийг Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэх, батлуулах, хэрэгжилтийг хангуулах, тайлагнах;

13.4.6 Ажлын албаны хүний нөөцийг бүрдүүлэх, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, шагнаж урамшуулах, хариуцлага тооцох;

13.4.7 Удирдах зөвлөл болон гишүүн мэргэжлийн холбоодыг мэдээллээр хангах.

Арван дөрөв. Мэргэжлийн зөвлөл

14.1 МНХ-ны дүрэм, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан асуудлууд болон Бүх гишүүдийн хурал, Удирдах зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар тухайн дэд салбар бүрээр гишүүн мэргэжлийн холбоодын хууль эрх зүйн, бодлого, стратегийн болон техник технологийн чиглэлийн холбогдох удирдах ажилтан, мэргэжлийн ажилтнуудаас бүрдсэн мэргэжлийн зөвлөлүүд ажиллах ба гишүүн мэргэжлийн холбооны Гүйцэтгэх захирал нь мэргэжлийн зөвлөлийн даргын чиг үүргийг гүйцэтгэнэ.

14.2 Мэргэжлийн зөвлөл нь тухайн мэргэжлийн холбооны гишүүдийнхээ болон салбарын тулгамдсан асуудлыг тодорхойлох, тэдгээрийн шийдлийн талаарх гишүүдийнхээ саналыг нэгтгэх, салбарын хууль, эрх зүй, бодлого, зохицуулалтыг сайжруулах чиглэлээр төрийн болон зохицуулах байгууллагад өгөх санал, зөвлөмж, мэдэгдэл, шаардлага зэрэг холбогдох баримт бичгийг боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

14.3 Мэргэжлийн зөвлөлөөс гаргасан тухайн дэд салбарын нийтлэг ашиг сонирхлыг хамгаалсан шийдвэр, санал, холбогдох баримт бичгийг МНХ-ны санал гэж үзнэ.

14.4 Мэргэжлийн зөвлөл холбогдох асуудлаар МНХ-ны хүрээнд Ажлын хэсэг байгуулж болно. Ажлын хэсэг байнгын эсхүл тухайлсан асуудлыг шийдвэрлэх түр ажлын хэсгийн аль ч хэлбэрээр ажиллаж болно.

Арван тав. Гишүүнчлэл, түүний эрх зүйн байдал

15.1 МНХ-ны зорилго, үнэт зүйлс, баримтлах зарчим, үйл ажиллагааны үндсэн чиглэл болон энэхүү дүрмийг хүлээн зөвшөөрч сайн дураар нэгдэхээ илэрхийлсэн, гишүүнд тавигдах шаардлагыг хангасан, Монгол Улсад бүртгэлтэй, харилцаа холбооны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн холбоодыг гишүүнээр элсүүлнэ.

15.2 Гишүүнд тавигдах шаардлага:

15.2.1 МНХ-ны зорилго, үнэт зүйл, баримтлах зарчим, дүрэм, бодлоготой танилцаж хүлээн зөвшөөрсөн байх;

15.2.2 Аливаа нам, улс төр, төрийн байгууллагаас хараат бус ажилладаг байх;

15.2.3 Салбарын болон МНХ-ны нийтлэг эрх ашгийг эрхэмлэж, аливаа асуудалд мэргэжлийн байр сууринаас ханддаг байх;

15.2.4 МНХ-ны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, цөөнхийн дуу хоолойг сонсдог байх;

15.2.5 Гишүүний татварыг хүлээн зөвшөөрсөн байх;

15.3 МНХ-нд гишүүнээр элсүүлэхдээ ялгаварлан гадуурхахгүй, нээлттэй байх, олон талт, ялгаатай байдал, туршлагыг төлөөлөхүйц байлгах бодлогыг баримтална.

15.4 Гишүүний баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээ:

15.4.1 МНХ-ны гишүүдийн нийтлэг ашиг сонирхлыг өөрийн холбооны ашиг сонирхлоос дээгүүр тавих;

15.4.2 МНХ-ны бусад гишүүдийг хүндэтгэж, ажил хэрэгч, соёлч боловсон, тэгш эрхтэй харилцах;

15.4.3 Салбарын болон МНХ-ны нэр хүнд, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхүйц үйлдэл, эс үйлдэл хийхгүй байх;

15.4.4 МНХ-ны талаар үндэслэлгүй, ташаа мэдээлэл өгөхгүй байх, үйл ажиллагаанд дарамт шахалт үзүүлэхгүй байх, үйл хэрэг, ажиллагааг сулруулах, хагалган бутаргах үйлдэл, эс үйлдэл хийхгүй байх.

15.5 Гишүүн нь дараах эрхтэй байна. Үүнд:

15.5.1 Гишүүнд элсэх, гишүүнээс гарах;
15.5.2 Удирдах зөвлөлд сонгогдох;
15.5.3 Эрх ашгаа хуулийн хүрээнд хамгаалуулах;
15.5.4 Тухайн дэд салбарынхаа асуудлаар МНХ-оог төлөөлөх;
15.5.5 Удирдах зөвлөлөөр хэлэлцэх асуудалд санал дэвшүүлэх;
15.5.6 МНХ-оос зохион байгуулж байгаа арга хэмжээ, төслийг дэмжих, хандив өргөх;
15.5.7 МНХ-оос зохион байгуулагдаж буй аливаа үйл ажиллагаанд нэн тэргүүнд, хөнгөлөлттэй нөхцөлөөр хамрагдах;

15.6 Гишүүн нь дараах үүрэгтэй:
15.6.1 МНХ-ны дүрэм, журам, шийдвэр, баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх
15.6.2 Гишүүнчлэлийн журмын дагуу гишүүний татвараа хугацаанд нь төлөх;
15.6.3 МНХ-ны албан ёсны шийдвэртэй зөрчилдөх байр суурийг илэрхийлэхгүй байх.

15.7 МНХ-ны дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсвэл хангалтгүй биелүүлсэн тохиолдолд гишүүнээс чөлөөлөх асуудлыг Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ

15.8 Дор дурдсан нөхцөлд гишүүнээс чөлөөлнө. Үүнд:
15.8.1 Гишүүн МНХ-оос гарах хүсэлтээ бичгээр гаргасан;
15.8.2 МНХ-ны дүрмийг ноцтой зөрчсөн;
15.8.3 МНХ-ны эрх ашиг, эв нэгдэлд харш, нэр хүндийг гутаахад чиглэсэн үйл ажиллагааг санаатай явуулсан, дэмжсэн, энэ төрлийн үйл ажиллагаанд оролцсон;
15.8.4 МНХ-ны нэрийг ашиглан хууль бус үйлдэл хийсэн нь тогтоогдсон;
15.8.5 Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гишүүнчлэлийн татвараа 1 жил болон түүнээс дээш хугацаагаар төлөөгүй;
15.8.6 Гишүүн мэргэжлийн холбоо татан буугдсан, дампуурсан тохиолдолд.

15.9 Гишүүнчлэлээс чөлөөлөх асуудлыг Гүйцэтгэх захирал Удирдах зөвлөлд танилцуулж, шийдвэр гарснаар тухайн гишүүнийг МНХ-ны гишүүнээс чөлөөлсөнд тооцно.

15.10 Гишүүнчлэлээс чөлөөлөгдсөн тохиолдолд гишүүний татвар, хандивыг буцаан олгохгүй.

15.11 Гишүүнээр элсүүлэх, чөлөөлөх асуудлыг энэхүү дүрмийг үндэслэл болгон Гишүүнчлэлийн журамд нарийвчлан тусгана.

Арван зургаа. МНХ-оог өөрчлөн байгуулах, татан буулгах нөхцөл

16.1 Дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд МНХ-оог өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргана. Үүнд:
16.1.1 Хуульд заасан үндэслэлээр өөрчлөн байгуулах, татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан;
16.1.2 Өөрчлөн байгуулах, татан буулгах талаар нийт гишүүдийн шийдвэр гарсан.

16.2 Татан буугдсан тохиолдолд эд хөрөнгийг гишүүдэд хуваарилан шилжүүлэх, эсвэл дүрэмд заасан зорилгод нийцсэн үйл ажиллагаанд зарцуулахаар Удирдах зөвлөлөөс шийдвэрлэнэ.

Арван долоо. МНХ-ны санхүүжилт

17.1 МНХ нь зорилго, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэртэй байна.

17.2 МНХ-ны орлого дараах эх үүсвэрээс бүрдэх ба Улс төрийн нам хүчнээс санхүүжилт авахгүй байх зарчмыг баримтална. Үүнд:

17.2.1 Гишүүний татвар, хандив;

17.2.2 Иргэд, аж ахуйн нэгж, олон улсын байгууллагын хандив, тусламж;

17.2.3 Гадаад, дотоодын байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төслийн ажлын төсөв;

17.2.4 Төрийн байгууллагын зарим чиг үүргийг хууль болон гэрээний үндсэн дээр гүйцэтгэснээс олсон орлого;

17.2.5 Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого;

17.2.6 Төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсөв, донор байгууллага, Засгийн газрын тусгай сангаас олгосон хөрөнгө;

17.2.7 Хуулиар хориглоогүй бусад орлого.

17.3 Гишүүний тухайн жилийн хураамжийн хэмжээ нь тухайн гишүүнийг төлөөлж байгаа Удирдах зөвлөлийн гишүүдийн тоог 20,000,000 (хорин сая) төгрөгөөр үржүүлснээс доошгүй байх ба хэмжээг Удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.

17.4 Гишүүний тухайн жилийн хураамжийн хэмжээнд үзүүлэх хөнгөлөлт, чөлөөлөх, нэмэгдүүлэх асуудлыг Удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

17.5 МНХ-ны санхүүгийн жил нь төсвийн жилтэй давхцах бөгөөд анхных нь бүртгүүлсэн өдрөөс эхэлж, тухайн жилийн 12 дугаар сарын 31-нд дуусна.

17.6 МНХ нь олсон орлогыг дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэхэд зориулан зарцуулах ба хэнд ч ашиг хуваарилан, зээл олгох, хөрөнгийн баталгаа гаргахгүй.

17.7 Ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн дарга ба гишүүн, Гүйцэтгэх захирал, ажлын албаны ажилтны хэн ч МНХ-ны эд хөрөнгөөр хувийн ашиг олох зорилгоор санхүүгийн буюу аж ахуйн үйл ажиллагаа явуулах, МНХ-нд хариуцаж буй ажил албан тушаалаа улс төр, бусад албан тушаалын зорилгоор ашиглахыг хориглоно.

---oOo---